

⁷ Халха Джирум. М., 1965. 266-р тал

⁸ **Х. Пэрлээ.** Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн бичиг. УБ. 1974 80-р тал

⁹ Их цааз (Великое уложение) Памятник монгольского феодального право XVII в М., 1981. 48-р тал.

¹⁰ Х. Пэрлээ. Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн бичиг. УБ., 1974 82-р тал

¹¹ Халха Джирум. М., 1965. 299-р тал

¹² **А. Очир.** Эртний монголчуудын цаг тооллын мэдлэгийг сарын нэрээр мөшгөх нь. «Этнографийн судлал» сэтгүүл, УБ., 1985. 17-р тал

¹³ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. (баримт бичгийн эмхтгэл, эмхтгэсэн А. Очир, Г. Пүрвээ, 306—307-р тал)

¹⁴ **Ц. Насанбалжир.** Монголчуудын байгаль ба байгаль орчны уламжлалт хамгаалалтын тухай, ОУМЭ-ний III их хурал. III боть, 1979. 216-р тал

¹⁵ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. (баримт бичгийн эмхтгэл) Эмхтгэсэн А. Очир, Г. Пүрвээ. УБ., 1982, 8, 10, 41, 42-р тал

**СОЦИАЛИСТ ЧИГ
БАРИМЖААТ ОРНУУД:
ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНСНИЙ
ХАНГАМЖИЙН БАЙДАЛ,
ТӨЛӨВ**

Ц. БААТАР

Социалист чиг баримжаат орнуудын эдийн засгийн үндсэн салбар нь хөдөө аж ахуй юм. Дотоодын нийт бүтээгдэхүүний 50 орчим хувь, экспортын 80—90 хувийг энэ салбар гаргана. Хүн амын 70—80 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж амьдарч байна. Энэ орнуудад хөдөө аж ахуйн хоцрогдлыг гэтлэн давах, хүнсний асуудлыг шийдвэрлэх нь өнөөдөр туйлын бэрхшээлтэй асуудал болоод байна.

Эдийн засгийн үзэгдлийн хувьд хүнсний асуудал нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүрээн дэх үйлдвэрлэх хүчний хөгжил, хүн амын өсөлт, нийгмийн хөгжлөөр нөхцөлдсөн олон хүчин зүйл (дотоод, гадаад) -ээс шалтгаална. Хөгжиж байгаа орны хөдөө аж ахуйн хоцрогдол, хүнсний асуудал эцсийн бүлэгт капиталист үйлдвэрлэлийн аргаас, түүний шулан мөлжиж ирсэн өнгөрсөн, өнөөгийн түрэмгий бодлогын уршигт үр дагавар юм.

Тодруулж хэлбэл хүрээлэн буй орчныг ихээхэн бохирдуулдаг үйлдвэрлэлийн төрлийг олон улсын монополиуд эдгээр оронд шилжүүлснээс болж экологийн асуудал хурцдаж аж ахуйн алдагдал улам ихсэв. Тухайлбал, дээрх оронд байгалиар нөхөн сэргээдэг нөөц-өнгөн хөрс устаж тариалангийн талбай, малын бэлчээр хужиртах, элсэнд идэгдэж цөлжих хандлага газар авч сөрөг үзэгдэл их гарч байна. Зарим үнэлгээнээс үзэхэд таримлын ургацын 40 хувь нь хөдөө аж

ахуйн хортонд идэгдэж ургаагаараа үхэж байна. Түүнчлэн халуун бүсийн бэлчээрт тэжээлийн ургамлыг хортон хогийн ургамал хөнөөснөөс малын ашиг шим 30 орчим хувиар буурч, өвчин паразитаас болж ихээр хорогдож байна.

Энэ зууны эхэнд Этиопийн нутаг дэвсгэрийн 50 хувийг ой мод эзэлдэг байсан бол одоо дөнгөж 3 хувийг эзэлж байна.¹ Энэ нь ган гачигт өртөх нэг үндэс болжээ.

Танзанид экологийн тэнцвэр алдагдаж бэлчээрийг нүүдэл, хагас нүүдлийн хэлбэрээр ашиглаж ирсэн мал аж ахуйн хөгжил улам доройтож байгааг судлаачид тэмдэглэж байна,²

Нөгөө талаар цэвэр усны нөөц улам бүр багасч хүн амын эрүүл ахуйд муугаар нөлөөлөх боллоо.

Хүрээлэн буй орчны байдал чингэж муудах нь нийгэм-эдийн засгийн хөгжилд ноцтой саад болдгийг шинэ тулгар орнуудын өнөөгийн гашуун туршлага харуулж байна.

Экологийн болон хүнс, хөдөө аж ахуйн нягт уялдаа холбоотой эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд социалист чиг баримжаат орнуудад хөрөнгө оруулалт маш хязгаарлагдмал байгаа юм. Тухайлбал Конго, Алжир улс орноо хөгжүүлэхэд төсвийнхөө 40—50, Мада гаскар, Этиоп 14—15 хувийг тус тус зарцуулж байхад Ангол, Мозамбикт түүнээс ч бага байна. Бараг бүх социалист чиг баримжаат орнууд улсын төсвийнхөө тал хувийг улс орны аюулгүй байдлыг батлан хамгаалахад зориулж байна. Гэтэл хөдөө аж ахуйд оруулах хөрөнгө өчүүхэн бага хувийг эзэлнэ.

Үүний улмаас хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ дорвитой нэмэгдэхгүй, хөдөлмөрийн бүтээмж ч үлэмж доогуур байна. Мозамбикт хөдөө аж ахуйн хөдөлмөрийн бүтээмж 1,3 хувь, бусад оронд түүнээс ч доогуур байгаа юм.³

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хүнсний асуудлыг шийдвэрлэх үндсэн нөхцөл гэвэл эдийн засгийн нийт хөгжлийг түргэтгэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөөд нийгэм-эдийн засгийн гүнзгий өөрчлөлт хийх, хүн амын өсөлтийг тодорхой хэмжээгээр тогтоон барих бодлого явуулах, эцэст нь олон улсын эдийн засгийн шударга шинэ дэг журам тогтоох замаар шийдвэрлэх бололцоотой юм.

Социалист чиг баримжаат нэлээд орны хувьсгалт ардчилсан нам, төр хоцрогдсон уламжлалт хөдөө аж ахуйг өөрчлөх нийт үйл явцад гагцхүү урт хугацааны төлөвлөгөөний үндсэн дээр л хэрэгжүүлж болох ардчилсан эрс өөрчлөлт хийх нь чухал гэдгийг иш үндэс болгож байна. Энэ нь газрын ардчилсан шинэтгэл хийх, хөдөө аж ахуйн хоршооллыг хөгжүүлэх явдал юм. Энэхүү тулгамдсан асуудлыг богино хугацаанд огцом түргэн шийдвэрлэх хялбар зүйл биш, харин түүхэн хөгжлийн тодорхой үе шатыг дамжиж тэмцэл бэрхшээлийг туулан хэрэгжих хувьсгалт үйл явц юм.

Одоо үед Этиоп, Ангол, Мозамбик, Өмнөд Йемен, Афганистан зэрэг социалист чиг баримжаат орнуудад хөдөө аж ахуйг өөрчлөн байгуулах хоршооллын энгийн хэлбэр хэрэгжиж эхлээд байна.

Хувьсгалт ардчилсан төр орон нутгийн болон гадаадын томоохон газар эзэмшигчдийн газрыг улсын болгож газаргүй буюу бага газартай тариачдад газар олгож тэдний аж ахуйн сонирхлыг дэмжиж тариачдын нөхөрлөл байгуулахад нь тал бүрээр тусалж байна. Эдийн засаг,

техникийн туслалцаа үзүүлж олон түмний боловсрол, улс төрийн идэвхийг дээшлүүлэхэд их анхаарч байна. Жишээлвэл Этиопийн ажилчны нам энэ талаар нэлээд далайцтай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Улс орны нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх 10 жилийн урт хугацааны өргөн программын хүрээнд уг арга хэмжээг хэрэгжүүлж эхлэв. Хөдөө аж ахуй, үүнтэй нягт уялдаа холбоотой үйлдвэрлэлийн бусад салбарыг хөгжүүлэх, эрчим хүч, тээвэр холбоо, зам харилцаа нийгмийн болон бусад олон асуудлыг хэрэгжүүлэхээр энэхүү программд тодорхой заажээ. Өнөөгийн байдлаар 6,5 сая гишүүнтэй 20 мянган тариачдын холбоо байгуулжээ.⁴ Эдгээр холбоо нь хоршооллох үйл явцын эхлэл, түүний бэлтгэл үе юм. Энэ бааз сууринд үндэслэн хоршоолол үндсэн хоёр хэв шинжтэй хөгжиж байна. Эхнийх нь хамтаараа газар тариалангийн үйлдвэрлэл явуулдаг нөхөрлөлийн хэлбэр юм. Энд газар нийтийн (хоршооллын) өмч, үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл гишүүдийн өмч байна. Хоршооллын хоёр дахь хэлбэрт газар, үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл хоёулаа хоршооллын өмч юм. Гэхдээ хоршооллын гишүүд хувьдаа бага зэрэг газартай, ойр зуурын багаж хэрэгсэл, малтай байх ажээ. Өнөөдөр хоршооллын дээрх хоёр хэв шинжийг хадгалсан мянга гаруй үйлдвэрлэлийн хоршоолол ажиллаж байна.

Этиопийн нийгэм-эдийн засгийг 1984 — 1994 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хөдөөгийн хүн амын 53 хувь, боловсруулсан талбайн 50 хувь хоршооллын мэдэлд байхаар заажээ.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд хамгийн багаар тооцоолоход 20-30 мянган орчин үеийн өндөр хүчин чадалтай, олон төрлийн ажил үйлчилгээ хийж чаддаг трактор шаардлагатай байгаа юм. ФАО-ын* мэдээ гээр 80-аад оны эхээр Этиопийн хөдөө нутагт мянган трактор, 150 комбайн ажиллаж байв. 1984 оны наймдугаар сард ЗХУ-ын тусламж-тайгаар Этиопт трактор угсрах үйлдвэр байгуулж ашиглалтад оруулсан юм. Засгийн газар хүнсний бүтээгдэхүүнээр өөрийгөө хангах асуудлыг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө үр тарианы ургацыг тасралтгүй нэмэгдүүлэх замаар хураах ургацын хэмжээг 1987—1988 онд 6,1 сая центнер, 1995 онд 14,4 сая центнерт хүргэх зорилт тавьж байна. Хөдөө аж ахуйд хөдөлмөрийн бүтээмж эрчимтэй өсч байна. Усалгаатай тариалан эрхэлдэг газар га-гаас авах ургацын хэмжээг ч нэмэгдүүлж чаджээ. Тухайлбал 1981 онд га-гаас 15,8 центнер ургац авч байсан болодоо түүний 20,3 центнерт хүргэсэн байна. Удахгүй га-гаас 24,7 центнер ургац хураан авах зорилт тавьж байна.

Хөдөө аж ахуйд нэн ялангуяа газар тариалангийн үйлдвэрлэлд усалгаатай тариалан эрхлэх, усжуулах талаар их анхаарч байгаа боловч материал, санхүүгийн боломж хязгаарлагдмал байна. Энэ бол нэг гол бэрхшээл юм.

Этиопийн нэг адил Мозамбикт улс орны хүнсний хангамжийг сайжруулах 20 жилийн программ гаргаж хөдөө аж ахуйг хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлжээ. Үүнд:

— Тариачдын хамтын хөдөлмөрийн үндсэн дээр байгуулж буй аж ахуйг дэмжин урамшуулж бэхжүүлэх;

— Улсын аж ахуйн удирдлагын арга хэлбэрийг боловсронгуй болгож материал-техникээр хангах явдлыг өргөтгөх;

*НҮБ-ын хүнс тэжээл, хөдөө аж ахуйн байгууллага.

— Хөдөө аж ахуй дахь гадаадын капиталд хяналт тогтоох зэрэг арга хэмжээнүүдийг юуны өмнө авч хэрэгжүүлэхээр заажээ.⁵

МПЛА — Хөдөлмөрийн намын шийдвэрээр Анголд хоршооллын хөдөлгөөнийг эхлээд нэг нийтлэг асуудлыг тухайлбал бүтээгдэхүүн борлуулах асуудлыг эрхлэх тариачдын холбоо байгуулах замаар хэрэг жүүлж эхэлжээ. Энэ холбоо нь эхлээд тариачдыг хамтран хөдөлмөрлөх явдалд дасган сургаж яваандаа улсын тусламжтайгаар хамтын өмчийг өргөтгөх арга замын үндсэн дээр анхан шатны хоршоолол болж өөрчлөгдөх аж. Тэгэхдээ хоршооллын гишүүд хувийн нэлээд газартай хэвээр байна. Хоршооллын дараагийн шатанд газрыг болон үйлдвэрлэлийн бусад хэрэгслийг өмчлөх нийгмийн өмч зонхилсон, ажлаа улсын төлөвлөгөөний үндсэн дээр төвлөрсөн журмаар удирдан төлөвлөдөг социалист маягийн хоршооллыг байгуулахаар төлөвлөжээ.

Колоничлогчдын орхисон нэлээд том хэмжээний хөгжингүй дэд бүтэц бүхий зарим аж ахуйнууд ч тийм хоршоололд нэгдсэн байна. 1985 онд Анголд 400 мянган гишүүнтэй 3,5 мянган тариачдын холбоо ажилаж байв.⁶

Хөдөө аж ахуйд техник нэвтрүүлэх талаар халуун бүсийн африкийн социалист чиг баримжаат орнуудын дотроос Ангол эхний байранд орно НҮБ-ын хүнс тэжээл, хөдөө аж ахуйн байгууллагын судалгаанаас үзэхэд 80-аад оны эхээр Анголын хөдөө аж ахуйд 10,3 мянган трактор ажиллаж байв.⁷

Мадагаскарт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлвэрлэдэг 50 хоршоолол байгаа аж. Хоршооллын аж ахуй 14,6 мянган гагазар эзэмшинэ. Эдгээр хоршооллуудад шинжлэх ухаан-техникийн орчин үеийн ололтыг нэвтрүүлэх, механикжуулах, цахилгаанжуулах, эрдэс бордоог өргөн ашиглах, услалтын систем байгуулах ажлыг нэлээд эрчимтэй хийж байна. Хоршооллын гишүүдийг гүйцэтгэсэн ажлынх нь хэр хэмжээгээр цалинжуулж, материаллаг урамшил үзүүлдэг байна. Мөн тэдэнд туслах аж ахуй эрхлэхийг нь ч зөвшөөрчээ.⁸ Энэ мэт арга хэмжээний үрээр Мадагаскарт хөдөө аж ахуйн салбар мэдэгдэхүйц амжилт олж одоо дотоодын нийт бүтээгдэхүүний 44,3 хувийг үйлдвэрлэж байна.

80-аад оноос социалист чиг баримжаат орнуудын хөдөө дэх шинэчлэлт, өөрчлөн байгуулалтын үндсэн хэлбэр болсон хоршооллох хөдөлгөөнийг түргэтгэхэд улсын сектор чухал үүрэг гүйцэтгэх болов. Этиопийн хөдөө аж ахуйн улсын секторт мал аж ахуй, газар тариалангийн 60 аж ахуй, улсын томоохон 7 сангийн аж ахуй, сүүний хэд хэдэн ферм ажиллаж байв. Этиопийн улсын сангийн аж ахуйнууд 1985-1986 онд 4,1 сая үр тариа хурааж авсан нь хөдөө аж ахуйн нийт ургац хураалтын 8 хувийг эзэлж байв.⁹

Мозамбикт 100 гаруй томоохон сангийн аж ахуй, хэд хэдэн хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн цогцолбор байгуулжээ. Түүнд тариачдын 10 хувь нь ажиллаж байна. Өнөөгийн байдлаар чихрийн нишингийн тал хувь, цайны ургамлын 80 хувийг улсын сектор гаргах боллоо. Мозамбикийн нийгэм-эдийн засгийг 1981 — 1990 онд хөгжүүлэх үндсэн чиглэлээс үзэхэд 1990 он гэхэд хөдөө дэх улсын сангийн аж ахуйн эдэлбэр газар 221 мянган га-гаас 1,4 сая га болж тэнд ажиллагсдын тоо 2,4 дахин өсөх юм. 1982 онд улсын сектор хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 15 хувийг үйлвэрлэж байв. Анголын хөдөө аж ахуйд томоохон улсын

сектор ажиллаж байна. 1980 онд 1900 улсын үйлдвэр, аж ахуйн газар ажиллаж, техникийн ургамлын тал хувь, үр тарианы гуравны нэг, мал аж ахуйн бүтээгдэхүүний дөрөвний нэгийг тус тус үйлдвэрлэж байв. Цагаан будаа, эрдэнэ шиш, наранцэцэг, хөвөн, төмс, гадил, ним-бэгний үйлдвэрлэл үндсэндээ улсын секторт төвлөрчээ.

Социалист чиг баримжаат орнуудын төрийнхүү дунд болон жижиг тариачдын аж ахуйг хөхүүлэн дэмжиж, гар урчуудад тусламж үзүүлж эдийн засаг, нийгэм, улс төр-зохион байгуулалтын талаар нэлээд далайцтай арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд зээл, борлуулалтын эд хэрэглэгчдийн зэрэг үйлдвэрлэлийн хоршооллын энгийн хэлбэрүүд өсөн бэхжиж байгааг дээрх жишээнүүд нотолж байна.

Социалист чиг баримжаат орнуудын хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуй чухал суурь эзэлнэ. Хүн амыг хүнс тэжээлээр, аж үйлдвэрийг түүхий эдээр хангахад энэ салбар гол үүрэг гүйцэтгэж байна. НҮБ-ын хүнс, тэжээл хөдөө аж ахуйн байгууллагын судалгаанаас үзэхэд өнөөгийн байдлаар Этиопт 68, Афганистанд 28, Анголд 27, Танзанид 22 Алжирт 17, Йеменд 12, Бенинд 3, Мозамбикт 2 сая орчим мал байгаа юм. Эдгээр оронд бэлчээрийн мал аж ахуй зонхилно. Бэлчээрийг нүүдэл, хагас нүүдлийн хэлбэрээр ашиглаж байна. Судлаачдын үзэж бай гаагаар Афганистан. Өмнөд Йемен, Этиоп зэрэг оронд бэлчээрийн мал аж ахуй эрхлэх илүү боломжтой ажээ.

Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүнд мал аж ахуйн бүтээгдэхүүн Алжир, Этиопт 70—80 хувь, бусад оронд 30—50 орчим хувийг эзэлнэ.

Малын байршлын хувьд авч үзвэл Азийн орны адууны 8,2, үхрийн 8,4, тэмээний 9,6, хонины 12, ямааны 4 хувь орчим нь Афганистанд, Африкийн орны адууны 47, үхрийн 26, тэмээний 11, хонь, ямааны 17 орчим хувь нь Этиопт тус тус байршжээ.¹⁰ Афганистан, Йеменд нийт малын 60—70 хувийг хонь эзэлнэ. Африкийн орны малын бүтэцэд үхэр, хонь, ямаа голлоно.

Социалист чиг баримжаат орнуудын хувьсгалт ардчилсан төр мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхдээ гол төлөв улсын секторт түшиглэж байна. Тухайлбал, Этиопт улсын секторт түшиглэн мал аж ахуйд үржил-селекцийн ажил явуулж, тэжээлийн асуудлыг шийдвэрлэх, мал аж ахуйг хөгжүүлэх судалгаа шинжилгээний төв байгуулжээ. Түүнчлэн 500—2000 саалийн үнээтэй 15 томоохон сүүний ферм ажиллаж байна.

ЭАН-аас хөдөө аж ахуйг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд хөдөөд улс хоршооллын сектор бэхжиж, үр тарианы төрөлжсөн аж ахуй байгуулж байгаа нь хүн амыг хүнсээр хангах, зах хязгаар нутгийн олон ястан үндэстний нэгдэл нягтралыг бэхжүүлэх, тэнд таваар мөнгөний харилцааг өргөжүүлэх боломж бүрдүүлсэн байна.¹¹

Мозамбикт мал аж ахуйн 8 томоохон ферм байгуулжээ. Анголд 93 мянган бод малтай мал аж ахуйн 300 цогцолбор ажиллаж байна. Өгүүлэн буй орнуудын төр бэлчээрийг улсын өмч болгосон хууль гаргасны дээр түүний ашиглалтыг зохицуулж, мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулж материал-техникээр хангах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, малчдын аж байдлыг сайжруулах талаар нэлээд арга хэмжээ авч байна. Хувьсгалт ардчилсан төрөөс авч хэрэгжүүлж

буй дээрх арга хэмжээний үр дүнд Бенин, Афганистан, Өмнөд Йеменд газар тариалан, мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх таатай боломж бүрдсэн байна. Энэ орнуудын мал аж ахуйн салбар дахь өөрчлөлт нь газар тариалангийн салбар дахь өөрчлөлттэй харьцуулахад харьцангуй удаашралтай явагдаж байна. Энэ нь мал аж ахуйн салбарын онцлог, малчдын нийгмийн асуудал нарийн түвэгтэй байгаад оршино.

Социалист чиг баримжаат орнуудын төр хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд концесс, хоршоолол, түрээс худалдааны зэрэг улсын капиталист хэлбэрийг зохистойгоор ашиглаж капиталист орнуудтай хувь нийлүүлсэн хамтарсан аж ахуй байгуулж байна.

Монголын хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчлөн байгуулах үйлс нь юуны өмнө газрыг улсын болгосны үндсэн дээр улсын секторыг хөгжүүлэх, ардын хувийн аж ахуйтныг социалист ёсоор хоршоолон нэгтгэх гэсэн өөр хоорондоо нягт холбоо бүхий хоёр чухал зорилтыг агуулж байлаа.

МАХН Шинжлэх ухааны социализмын сургаалийг үндэс болгон өөрийн орны түүхэн тодорхой нөхцөлийг харгалзан үзсэний үндсэн дээр улсын газар, нийгмийн хүч хөрөнгөнд шууд тулгуурласан, үйлдвэрлэлийг жинхэнэ ёсоор хөтлөхийн үлгэр дууриалал болохуйц улсын аж ахуйг байгуулах нь хөдөө аж ахуйг өөрчлөн хувиргах шийдвэрлэх хүчин зүйлүүдийн нэг гэж үзсэн юм.

Улсын аж ахуйг байгуулан хөгжүүлэхгүйгээр хөдөө аж ахуйг бүхэлд нь социализмын замд эргэлт буцалтгүй гаргах бололцоо байсангүй. Учир нь хувийн өмчтөн малчин ардуудыг социалист ёсоор хоршоолохын тулд юуны түрүүнд тэдэнд хамтын аж ахуйн давуу талыг итгүүлэх, үнэмшүүлэх тэдний оюун санааг өөрчлөх нь зайлшгүй чухал болсон байна. Энэ бүхнийг үндэс болгож улс орны нийгэм-эдийн засгийн онцлогийг харгалзан хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчлөн байгуулж эхэлсэн Зөвлөлтийн туршлагад үндэслэн сангийн аж ахуйг улсын өмчинд тулгуурлан байгуулж мал аж ахуй газар тариаланг хослуулан хөгжүүлсэн явдал улс нийгэмд чухал хэрэгтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тууштай нэмэгдүүлж чадсан юм. Улсын сангийн аж ахуйг бэхжүүлэхэд ЗХУ-ын техник эдийн засгийн тусламж чухал үүрэг гүйцэтгэжээ.

Сүүлийн үед хөрөнгөтний зарим монголч эрдэмтэд БНМАУ-ын капиталист биш хөгжлийн замын түүхэн туршлагыг хөгжиж байгаа орон түүний дотор социалист чиг баримжаат орнуудтай харьцуулан судлах асуудалд их анхаарал тавих болов. Тухайлбал БНМАУ-д олонтаа ирж хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчлөн байгуулсан манай орны туршлагыг судалж энэ талаар олон бүтээл туурвисан Японы монголч эрдэмтэн М. Онуки Ази, Африкийн олон оронд хүнс тэжээл, хөдөө аж ахуйн асуудал улам хүндэрч байгаа энэ үед Монголын туршлагыг дээрх орнуудтай харьцуулан судлах явдалд их ач холбогдол өгч анхаарвал зохих хэд хэдэн тодорхой санал дэвшүүлжээ.¹²

Түүний шавь, залуу монголч эрдэмтэн М. Мурай БНМАУ-ын капиталист биш хөгжлийн түүхэн замналыг социалист чиг баримжаат орнуудтай харьцуулан судалж капиталист биш хөгжил, социалист чиг баримжааны нийтлэг болон өвөрмөц шинжүүдийг тодруулах оролдлого хийж, капиталист биш хөгжлийн замын онолын зарим маргаантай асуудлыг бодитойгоор авч үзсэн байна.¹³

Социалист чиг баримжаат орнуудын төрөөс хөдөө аж ахуй, түүний хүнсний салбарт онцгой анхаарал тавьж, улс, хоршооллын секторыг бэхжүүлэхийн тулд эдийн засаг, нийгэм-улс төр, зохион байгуулалтын талаар нэлээд арга хэмжээ авч байгаагийн үрээр мэдэгдэхүйц амжилт олж байгаа боловч өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Тохиолдож байгаа нийтлэг бэрхшээл гэвэл хөдөөгийн хүн амын бичиг үсэг үл мэдэх явдал мэргэжилтэн хүрэлцээгүй байдал, хөдөө аж ахуйн эдийн засаг, төлөвлөлтийн байгууллагуудын туршлага дутмаг, шинжлэх ухаан-техникийн чадамж энэ талын судалгаа шинжилгээний байгууллага бэхжээгүй зэрэг олон асуудалтай холбоотой юм.

Социалист чиг баримжаат орнуудын хөдөө аж ахуй дахь өөрчлөн байгуулалтын өнөөгийн үйл явц хэдийгээр ийм нарийн ээдрээтэй хүнд хэцүү байгаа ч гэсэн улс хоршооллын сектор бэхжиж тариалан, бэлчээрийн талбайг өргөтгөх, мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүн амыг хүнсээр, аж үйлдвэрийг түүхий эдээр хангах, улс хоршооллын салбарын уялдаа холбоог сайжруулах талаар тодорхой арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байна.

Хөгжиж байгаа орны хөдөө аж ахуйг хөгжүүлэх хүнсний асуудлыг шийдвэрлэх талаар өнөө үед муугүй зөвлөмж, үйл ажиллагааны программ, бусад баримт бичиг боловсруулжээ. Олон зөвлөмж үйл ажиллагааны программд газрын үндсэн шинэтгэл хийх, хөдөө аж ахуйн хоршоолол зохион байгуулах, олон үндэстний корпорацуудын ажиллагааг хязгаарлах, тэдгээрийг хянах мэтийн дээрх асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн ардчилсан иж бүрэн өргөн арга хэмжээ авахаар заажээ.

Чөлөөлөгдсөн орнуудын хөдөө аж ахуйг хөгжүүлэх хүнсний асуудлыг шийдвэрлэх хэтийн төлөвийн талаарх янз бүрийн үзэл бодлын гол дутагдал нь иж бүрэн хандлага байхгүй, уг асуудлын нийгэм-эдийн засгийн шинж чанарыг дулимаг үнэлсэн, хөдөө аж ахуйг капиталист замаар хөгжүүлэх нь хөгжиж буй орнуудын хөдөөний хөдөлмөрчин олон түмэнд нийгмийн хувьд зохисгүй уршигтайг бүрхэгдүүлэх гэсэн санаархал юм.

Дээрх асуудлаар НҮБ-аас гаргасан олон баримт бичгийн ердийн сул тал бол нийгэм-эдийн засгийн дэвшилд хүрэх талаар социалист орнуудын хуримтлуулсан туршлага, энэ асуудлаар тэдгээр орны баримталж байгаа байр суурийг үл ойшоох буюу зориуд дуугүй өнгөрдөг явдал юм. Гэтэл шинэ тулгар хөгжиж байгаа орнуудтай ЗХУ болон социалист бусад улс эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллаж байгаа практик нэн чухал ач холбогдолтой.

Социалист чиг баримжаат орнуудад хөдөө аж ахуйгаа өөрчлөн байгуулах, хүнсний асуудлыг шийдвэрлэх, хүрээлэн буй орчноо хамгаалахад нь социалист орнуудын үзүүлсээр байгаа тусламж дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэж ирлээ.

Социалист хамтын нөхөрлөлийн орнууд одоо ч гэсэн урьдын адил дээрх орны хөдөө аж ахуйд техник-эдийн засаг, шинжлэх ухааны дэмжлэг үзүүлэхэд хүч чармайлтаа төвлөрүүлж, үйлдвэр хөдөө аж ахуйн цогцолборын өндөр үр ашигтай салбар болгох үндэс тавих боломж олгож байна. Усжуулах том төхөөрөмж байгуулах, агро-техникийн арга хэмжээ авах, орчин үеийн техник нийлүүлэх, хөдөө аж ахуйн дэвшилт чиглэлийг дэмжихэд үзүүлэх тусламж энд бас ха-

маарч байна. Социализмын орнуудын үзүүлж буй тусламжийн хэлбэр төрөл хямралын нөхцөлд Африк юм уу Азийн аль нэг орны засгийн газрын боловсруулсан хөдөө аж ахуй хүнсний асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөөний нягт уялдаж, тус орны хэрэгцээг харгалздаг юм.

Социалист чиг баримжаат орнуудын төр дотоод гадаад бодлогодоо социалист чиглэлийг тууштай баримталж, дэлхийн улс орнуудтай харилцан ашигтай хамтран ажиллаж, капитализмыг эсэргүүцсэн шинжтэй нийгэм-эдийн засгийн эрс өөрчлөн байгуулалт хийсэн нөхцөлд л хөдөө аж ахуй хүнсний асуудлыг нааштайгаар шийдвэрлэх бүрэн боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

¹ «Правда» I марта 1988.

² **К. Arhem.** The Maasai and the state: The impact of rural development policies on a pastoral people in Tanzania-Copenhagen: Intern. work group for indigenous affairs, 1985, dok. N 52. p. 23-31; Havnevik K. J., Skarstein R. Some notes on agricultural backwardness in Tanzania-In: Poverty and aid ed. by Parkinston J. R Oxford, 1983, p. 160—162

³ Экономические проблемы развития стран социалистической ориентации м. 1986. с. 47

⁴ «Азия и Африка сегодня» No 12, 1986, с. 19—20

⁵ Народная Республика Мозамбик справочник М., 1985, с. 107

⁶ **Л. Л. Фитуни.** Народная Республика Ангол. справочник М., 1985, с. 129.

⁷ Production yearbook FAO. Rome. 1982

⁸ «Ази и Африка сегодня» No 6, 1985, с. 40.

⁹ «Правда» 20 марта 1987.

¹⁰ **Б. Мягмаржав,** Бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн зарим асуудал. УБ, 1985, 126—127-р тал

¹¹ **A. Wood.** Rural development and national integration in Ethiopia - Afr. affairs L., 1983, vol. 82, N 329, p. 530—535

¹² **М. Онуки.** Монголын нүүдлийн мал аж ахуйн социалист өөрчлөлтийн зарим онцлог шинж, түүний ач холбогдол «Монгору Кэнкю» сэтгүүл 1987, No 10, 35—36 дахь тал

¹³ **М. Мурай.** Капиталист биш хөгжлийн онол ба Монгол- «Монгору Кэнкю сэтгүүл. (Япон хэлээр) 1984 No 7. 46—57-р талд дэлгэрэнгүй үзнэ үү.

**БНХАУ-Д ЖУУЛЧЛАЛЫГ
ӨРГӨЖҮҮЛЖ БАЙГАА ТУХАЙ**
Л. ЛХАМДУЛАМ

Жуулчлал нь аливаа улс орны байгалийн гоо сайхан, түүх дурсгалын зүйлс, ард түмний аж байдал, зан заншил, орчин үеийн хөгжилттэй танилцуулж, улс хоорондын харилцааг өргөжүүлэхэд түлхэц үзүүлдэг төдийгүй тухайн орны санхүүгийн хувьд зарлагаа богино хугацаанд нөхдөг, гадаад валютын нөөцөд «цэвэр» ашигтай салбар юм.

Сүүлийн жилүүдэд Хятадын цагаан хэрэм, Ханьжоу, Юньнань, Гуйлины байгалийн үзэмж төгс цогцолборууд, Бээжин хотын Мин ул-